


ЖИЛИЙН ТАЙЛАН
2020

САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

2020 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН МЭДЭЭГЭЭР НИЙТ 67061,1 МЯНГАН ТОЛГОЙ МАЛ ТООЛОГДСОН БАЙНА.



Малын нийт тоо өмнөх оноос **3.9 сая (5.5%)** үүнээс

хонь 2.2 сая (6.9%),
ямаа 1.5 сая (5.3%),
адуу 122.1 мянга (2.9%),
үхэр 21.8 мянга (0.5%)- аар тус тус буурч,

тэмээ 521 толгойгоор (0.1%) өссөн байна.



ҮХЭР

2020* 67 061.1



2019 70 969.3



ТЭМЭЭ

4 731.4



4 753.2



АДУУ

4 092.7



4 214.8



ХОНЬ

30 045.6



32 267.3



ЯМАА

27 718.5



29 261.7

Бид малын тоо толгойг зориуд дурдсан нь Яагаад, яаж гэсэн 2 асуултад хариу өгч махны үйлдвэрлэл, хангамж, экспортын талаар ойрын үед хийх ажлын чиглэлийг зөв оновчтой тодорхойлохыг зорьж байгаа юм.

Тухайлбал:

а. Яагаад 60,0 гаруй сая малтай манай улс 3,0 сая гаруйхан иргэнээ, ялангуяа хот суурин газрын оршин суугчидаа чанарын шаардлага хангасан эрүүл мах махан бүтээгдэхүүнээр жигд тогтвортой хангаж чадахгүй байна вэ?

б. Яагаад бид нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлохын оронд үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар малын гаралтай бүтээгдэхүүнүүдийг экспортлож байгаа вэ?

Яаж бид энэ хоёр асуудлыг шийдэх вэ?

Байгалийн цэвэр бүтээгдэхүүн, түүний дотор бэлчээрийн малын мах улам бүр үнэд хүрч түлхүү хэрэглэгдэх хандлагатай болсон өнөө үед бэлчээрийн малын махыг нэмүү өртөг шингээн, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр ТУЗ болон компанийн захиргаа тодорхой ажлуудыг төлөвлөж байна.

Дээрхи асуудлыг шийдвэрлэхэд хувьцаа эзэмшигч та бүхний гаргасан санал санаачлагыг хүлээн авч хэрэгжүүлэх болно.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

1. ҮЙЛДВЭРЛЭЛТ

Экспортыг нэмэгдүүлж БНХАУ-д 2000 тн адууны шулсан мах, ИБНИУ-д 1000 тн хонины ангилсан мах нийлүүлэх.

2. ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн эргэн мөшгих тогтолцоог үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

3. ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Хөргөлтийн системийн найдвартай ажиллагааг хангахад аммиакны насос, ус хөргөх төхөөрөмж, конденсаторын усны насосуудыг шинээр худалдан авч суурилуулах

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ

1. ҮЙЛДВЭРЛЭЛТ

Өөрийн үйлдвэрт 34 мянган адуу төхөөрч, экспортын зориулалтаар шулж ангилан БНХАУ-д 3350 тн шулсан мах экспортлосон.

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судлан хонь, үхрийн махыг ангилан савлаж онлайн худалдаагаар худалдаалж байна. Нийслэл хотын хүн амыг эрүүл, чанарын шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүнээр хангахад онцгой анхаарч нийт 910 тонн нөөцийн махыг ангилан савлаж, засгийн газраас тогтоосон хямдруулсан үнээр худалдан борлуулсан. Хиам үйлдвэрлэлийн гол хэрэгцээ хонь, үхрийн махыг үйлдвэрийн аргаар 100% бэлтгэн нийлүүллээ.

2. ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гарал үүсэлээр баталгаажсан 100% эрүүл бүс нутгаас бэлтгэсэн малыг үйлдвэрийн аргаар төхөөрч эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангасан орчинд ангилж савлан дотоод гадаадын зах зээлд нийлүүлж байна.

3. ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд 16 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аммиакын болон усны насосуудыг худалдан авч суурилуулсан.

Мах ангилан боловсруулах үйл ажиллагаанд зориулан БНХАУ-ын Hebei Xiaojin компаниас 50.3 сая төгрөгийн JRD160 маркын махны волчок ашиглалтанд оруулж үйлдвэрлэл явуулж байна.

4. Эрчим хүчний хэмнэлтийн талаар

5. ТЕХНИК ТЕХНОЛОГИ

Байгалийн гайхамшигт амт, давтагдашгүй чанарыг дэвшилтэд технологиор хүргэх нь бидний зорилго.

2020 онд “Мах импэкс”

ХК-ийн технологийн шинэчлэлийн хүрээнд бүтээгдэхүүний савлагааг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангах, үйлдвэрлэлийн орчинг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

4. Эрчим хүч хэмнэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаа

- ✓ Компанийн хэмжээнд Эрчим хүч хэмнэх аудит хийлгэн тодорхой төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ онд уурын конденсатыг эргүүлэн ашиглах ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтанд орууллаа.
- ✓ Хөргөлтийн алдагдлыг бууруулах зорилгоор мах хадгалах зоориудын хаалгыг өөрсдийн хүчээр шинэчлэж хийсэн.
- ✓ Хуурмаг чадлыг бууруулах зорилгоор COSφ-г 95 хувьд тогтмол барьж цахилгаан эрчим хүчийг хэмнэж ажиллаа.

5. ТЕХНИК ТЕХНОЛОГИ

- ✓ Манай үйлдвэр нь махыг нэг үе шаттайгаар хөлдөөдөг технологитой байсныг өөрчлөн гулууз махыг 24 цаг сэврээх, агшин зуур гүн хөлдөөх /-40⁰с-ийн хэмд/ 2 үе шаттай дэвшилтэт технологийг хэрэгжүүлснээр экспортын шаардлагыг хангаж, шинэлэг, зөөлөн, шүүслэг мах үйлдвэрлэх боломж бололцоог бүрдүүлж байгаа юм. Энэ онд 10 тн-ийн хүчин чадалтай -40⁰с хэмд гүн хөлдөөх нэг агуулах нэмж ашиглалтанд оруулсан.
- ✓ Сүүлийн үед хэрэглэгчид хүнсэндээ дотор, дайвар бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх болсонтой уялдуулан жижиглэн савласан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт нэмэгдсэн. Сахарын өвчтэй хүмүүст зориулан хонины салбант сархинагийг жижиглэн савласан нь эрэлт хэрэгцээ ихтэй болж байна.
- ✓ Хөдөө орон нутгаас амьд мал тээвэрлэх асуудал хүндрэлтэй байгаа үед компани өөрийн зориулалтын унаагаар малыг зовоохгүй тээвэрлэж байгаа нь махны чанартай шууд холбоотой ба эрүүл аюулгүй, найдвартай бүтээгдэхүүн хэрэглэгчиддээ хүргэх гол ажлыг шийдэх эхний алхам болсон.

ҮХЭР, ХОНИНЫ МАХ



Бэлчээрийн үхрийн мах нь хүний өсөлт хөгжил, бие махбодийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай уураг өөх тос, амин дэм болон шимт бодисыг цогцоор агуулдаг хүнсний цорын ганц агаад хосгүй үнэт түүхий эд юм. Таван хошуу мал нь соргог бэлчээрт идээшлэн усны тунгалагаас ундаалдаг тул биологийн үнэт чанар нь өндөр байдаг.

Монгол үхрийн мах булчингийн эд өөх алагласан бүтэцтэй маш нарийн ширхэгтэй тул амт үнэр нь гойд сайхан, тослог шим тэжээлтэй. Үхрийн сээр, нуруу, гол мах нь хамгийн зөөлөн, шүүслэг, нарийн ширхэгтэй, дээд зэрэглэлийн мах юм.

ДОТОР МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН



Дотор мах, дайвар бүтээгдэхүүн нь төгс уургийн агууламж өндөртэй, үл орлогдох амин хүчил, эрдэс бодис ихээр агуулдаг тул хүний биед зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүн юм.

Онцлог бүтээгдэхүүний танилцуулга:

Сархинаг нь кальци, натри, магни зэрэг эрдэс бодис ихээр агуулдаг нь нойр булчирхайн өвчнийг анагаахад тустай.

Сархинаг хэрэглэх заавар: 7 ширхэг сархинагийг 3 тэнцүү хувааж, нэг хэсгийг 250 гр усанд хийж 200 гр болтол буцалгана. Шөлийг орой унтахын өмнө ууна. Энэ жороо 3 долоо хоног хэрэглэвэл нэг курс эмчилгээ болно.

КОВИД-19

Бидний үүрэг – Эрүүл Монгол хүн

Ковид 19 цар тахлын үед төлөвлөгөөт ашиг буурсан, зарим хийгдэх хөрөнгө оруулалт болон засвар үйлчилгээний ажлууд хойшлогдоод байгаа боловч нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг тогтмол хэрэгжүүлж байгаа болно.

- ✓ Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулахын тулд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвөөс мэргэжилтэн урьж Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэн өгсөн зөвлөмжийн дагуу цаашдын ажлаа төлөвлөн ажиллаж байна.
- ✓ Ажлын байрыг багасгалгүй, хэвээр хадгалан, үйлдвэрлэлтийн хэмжээг тогтмол явуулж байна.
- ✓ 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг цалинтай амраах, гэрээсээ ажлаа хийх нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.
- ✓ Нийт ажилчдын дархлааг дэмжих, амин дэм ихтэй аарц, аньс, чацарганы шүүсийг өдөр бүр өгөх, шим тэжээл сайтай өдрийн хоолоор ханган ажиллаж байна.
- ✓ Цагаан сар, шинэ жил, наадамьн баярыг тохиолдуулан нийт ажилтнуудад хүнсний нэг сарын мах гурилын хэрэглээгээр хангадаг уламжлалтай.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бидний үүрэг – Эрүүл Монгол хүн

“Мах импэкс” ХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлууд

- ✓ Компанийн ажилчдыг Короно вирусын халдвараас хамгаалах зорилгоор ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж, нэг удаагийн маск, хамгаалах хэрэгсэлээр байнга хангаж, дархлаажуулалтын аян зохион байгуулж 20 гаруй сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.
- ✓ Корона вируст халдвараас сэргийлэх, эмчилгээнд зориулан Эрүүл мэндийн яаманд группын нийт компаниудтай хамтран ажилчдын 1 өдрийн цалин 26,14 сая төгрөг хандивлав.
- ✓ “Сонгинын бургас” ТББ, Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо ТББ-тай хамтран нийгмийн эмзэг давхрагын нэн ядуу хөгжлийн бэрхшээлтэй ахмад настангууд болон компанийн өндөр настангуудад бүтээгдэхүүний дээж өгөх ажлыг тогтмолжуулаад байна.
- ✓ Малчдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зудад өртөх эрсдэл бүхий аймгуудаас тарга хүчний үзүүлэлт дунджаас доош байгаа 21697 толгой малыг худалдан авч малчдын орлогыг нэмэгдүүлэх ажил зохион байгууллаа. Орон нутгийн мал төхөөрөх үйлдвэрүүдэд төхөөрсөн ямааны 600 тонн орчим махыг өөрийн үйлдвэрт авч, махыг боловсруулан БНХАУ-д экспорлох ажлыг бусад компаниудтай хамтран зохион байгуулсан. Энэ онд зудтай аймгуудаас нийт 920 орчим тонн мах бэлтгэн нийлүүлсэн байна. /Зудад нэрвэгдсэн аймгуудын танилцуулгыг хавсаргав./

Зудад нэрвэгдсэн аймгуудын танилцуулга




ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Эерэг хандлага, өндөр чадамж бүхий хамт олныг хөгжүүлнэ

Бид амжилтын үндэс суурь болсон ажилтнуудаа чадавхижуулах, бүх талаар хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгож, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар урт хугацаанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэхийг эрмэлздэг.

Мах импэкс ХК нь 2020 оны эцсийн байдлаар нийт 117 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллав.

ХҮЙСИЙН ХАРЬЦАА



”Мах импэкс” ХК 24 ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэж холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг 14 бүлэг, 98 үзүүлэлтийн дагуу үнэлүүлээ.

Боловсролын түвшин



2021 ОНЫ ЗОРИЛТ

1. Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудынхаа хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ, шинэлэг санаа, санаачлагын аяныг өрнүүлэн, бүтээлч санаачлагыг дэмжих, нэгдсэн зохион байгуулалттай тогтолцоог бий болгох.
2. Харилцагч, хэрэглэгчидтэй хамтран ажиллах бодлогод сайжруулалт хийх, цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх. Жижиглэн савалгааны цехийг орчин үеийн шаарлагад нийцүүлэн шинэчлэх.
3. Хөргөлтийн хүчин чадлыг нэмэгдүүлж мах хөлдөөх 4 туннель, 4 блоклон хөлдөөгч, 10 зоорийг найдвартай байнга ажиллуулахын тулд 2700 квт хүйтэн үйлдвэрлэх хүчин чадлыг бий болгох.
4. БНХАУ-д экспортлож буй бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд шинэчлэл хийж тухайн орны зах зээлд танигдах, ижил нэр төрлийн бүтээгдэхүүнээс ялгарах онцлог шинж чанарыг бүрдүүлэх.
5. Нийслэл хотын хүн амыг эрүүл, чанарын шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүнээр хангах, нийт 1600 тонн нөөцийн махыг бэлтгэн нийлүүлэх.
6. Орон нутагт бэлтгэсэн махны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд махыг өлгөж гүн хөлдөөх зохион байгуулалтын арга хэмжээ авч, өдөрт 20-30 тн мах хөлдөөх боломжийг бүрдүүлэх.
7. Хөргөлтийн конденсаторууд суурилагдсан төвөгшил ихтэй барилгын дээврийг шинэчилж барилга, тоног төхөөрөмжийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах
8. Компанийн ойрын болон хэтийн бизнес төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.
9. Энэ онд 3000 тонн махыг үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэхийн тулд мал бэлтгэлийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.